

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04-р сарын 21-ний өдрийн Лхагва гаригт 10.00 цагт мэссэнжэр чат ашиглан онлайн байдлаар зохион байгуулав. Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч оролцсон нь 59,670 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 94,03% болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69.1-т зааснаар ХЭХ хуралдуулах ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болсныг тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн мэдээллэв.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. 2012.03.14-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 74-р тогтоолын дагуу Хувьцаат Компанийн дүрмийн үлгэрчилсэн загварыг удирдлага болгох шийдвэрийн хүрээнд компанийн дүрмийг шинэчилэн батлах
2. Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
5. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв батлах

АСБИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал:

Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, хурлын ирцийг Тооллогын комиссийн дарга Б.Доржсүрэн:

-Энэ удаагийн ХЭХурал цар тахалтай холбоотойгоор цомхон бөгөөд товчхон, гол хэлэлцэх асуудлуудаа шуурхай хэлэлцээд дуусгах саналтай байна. ХЭХ-ын ирцийг танилцуулъя.

Нийт 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Энэ нь нийт саналын 94.03% хувь болж байгаа тул хурал хүчин төгөлдөр болж байна.

Хурал нээж Д.Лхагвасүрэн:

-Ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн тул хурал нээснийг мэдэгдье. Энэ удаагийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг бүгд мэдэж байгаа тул шууд санал хураалтаар шийдвэрээ гаргаад явах нь зөв гэж үзэж байна.

Хэлэлцэх асуудал 1. Компанийн дүрмийг шинэчилэн батлах, эсэх

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59,670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал 2. - . Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт, Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59,670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал 3. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
Гишүүдийн танилцуулгыг танилцуулж хүргүүлсэн байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Д.Лхагвасүрэн 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Л.Сүмбанд 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
3. Ч.Дашцэрэн 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
4. С.Буман-Эрдэнэ 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
5. Б.Доржсүрэн 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
6. Л.Түвшинзаяа 59,670 ширхэг буюу 100%-ийн санал

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Э.Буянтогтох 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Л.Нямдаваа 59,670 ширхэг буюу 100%-ийн санал
3. Ц.Хадаа 59,670 ширхэг буюу 100%-ийн санал тус тус 100%-ийн санал өгсөн байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалт, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй болж байна.

Хэлэлцэх асуудал 4. - Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв батлах

Энэ жилийн ТУЗ-ын төсвийг 8,000,000 сая төгрөгөөр батлуулахаар оруулсан байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59,670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоол баталж, Хурлын дарга Д.Лхагвасүрэн дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар ХЭХ-ын тогтоол тус бүрийг уншиж танилцуулан батлав.

Мөн 2020 онд цар тахалтай хүнд нөхцөл байдалд байсан хэдий ч ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараахаар болсон. Ногдол ашиг тараах ТУЗ-ын шийдвэрийн дагуу ҮЦТХТ-өөс ирүүлсэн тархалтын судалгаанд үндэслэн хувьцаа эзэмшигчдэд 2021 оны 2-р улиралд багтаан ногдол ашгийг олгохыг Гүйцэтгэх захирал Л.Сүмбандад үүрэг болгов.

Ийнхүү энэ удаагийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.ЛХАГВАСҮРЭН

С.БУМАН-ЭРДЭНЭ

Б.ДОРЖСҮРЭН

